



Томуугийн тандалтын тогтолцооны мэдээ, мэдээллийг бодлого боловсруулах, шийдвэр гаргах, хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд хэрхэн ашиглах тухай


Ерөнхий ойлголт:

- Тандалтын тогтолцооны суурь зарчим нь шийдвэр гаргагч нарыг хамгийн бага зардлаар, хугацаа алдалгүйгээр, үнэн зөв мэдээллээр хангах юм.
- Ингэснээр хариу арга хэмжээг цаг алдалгүй авч хэрэгжүүлэх, НЭМ-ийн арга хэмжээнд шаардлагатай хязгаарлагдмал нөөцийг зөв зохистой хуваарилах, зарцуулах, үр ашиггүй зардал гаргахаас сэргийлэх ач холбогдолтой.

Тандалтаар цуглуулсан мэдээг хэрэгжүүлж буй арга хэмжээнээс хамаарч

Тухай бүрд	Дэгдэлтийн үед
	Шинээр үүссэн НЭМ-ийн ноцтой байдлын үед
	Хүн амын эрүүл мэндийн байдал өөрчлөгдөх
	Антибиотикийн мэдрэг чанар өөрчлөгдөх
	Тухайн өвчний эрсдэлтэй хүн амын тархалт өөрчлөгдөх
Тодорхой үечлэлтэйгээр	Эрүүл мэндийн асуудлуудын хүч, түүний эдийн засгийн зардлыг тооцох
	Хяналтын арга хэмжээний үр нөлөөг үнэлэх
	Эрүүл мэндийн судалгааны тэргүүлэх чиглэлийг тогтоох
	Өвчний эрсдэлт хүчин зүйлийг тогтоох
	Эрсдэлт хүчин зүйлийг хянах
	Эрүүл мэндийн байдлын өөрчлөлтийг хянах
	Осол, гэмтэл, хордлого, өвчний мэдээллийг баримтжуулах
Сан үүсгэх	Өвчний эмгэг жамыг судлах
	Тархварзүйн болон лабораторийн судалгаа хийх
	Мэдээллийн баталгаажуулалтыг хийх
	Судалгааны тэргүүлэх чиглэлийг тогтоох
	Осол, гэмтэл, хордлого, өвчний мэдээллийг баримтжуулах

НЭМ-ийн хариу арга хэмжээ болон тандалтын тогтолцооны уялдаа



Томуугийн харуулдан тандалтын тогтолцоо

Сонгосон тандалтын нэгжүүдээс удирдамжийн дагуу томуу, томуу төст өвчин, амьсгалын замын цочмог хүнд халдварын тархварзүйн болон лабораторийн шинжилгээний мэдээллийг


- тогтмол цуглуулан,
- дүн шинжилгээ хийж,
- бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд, шийдвэр гаргагчдыг эргэн мэдээллээр хангах чиг үүрэг бүхий тогтолцоо

Томуугийн харуулдан тандалтын тогтолцооны үндсэн зорилго

- I. Томуугийн шинж байдал
- II. Босго үзүүлэлтийг тодорхойлох
- III. Улирлын томуугийн өвчлөлийг үүсгэж буй вирүсийн омгийг тодорхойлох
- IV. Урьдчилан сэргийлэх арга хэмжээний стратегийг боловсруулах
- V. Томуу, томуу төст өвчний дэгдэлтийг эрт илрүүлэх, түргэвчилсэн үнэлгээ хийх
- VI. Хариу арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх

ТОМУУГИЙН ТАНДАЛТЫН ТОГТОЛЦОО

- I. Амбулаторид суурилсан ТТН – 100
- II. Эмнэлэгт суурилсан ТТН – 38
- III. Нэмэлт тандалтын нэгж – 18
 - Боомт – 14
 - Лавлагаа эмнэлэг – 4
- IV. Вирус судлалын лаборатори – 30




173 нэгж



156 нэгж

Томуугийн харуулдан тандалтын тогтолцооны мэдээллийн урсгал



→ Мэдээлэл солилцох
 - - - Сорьц цуглуулах
 ← Вирусийн өсгөвөр, мэдээлэл солилцох

Тандалтын тогтолцоогоор цуглуулж буй мэдээлэл

1.8. Томуугийн харуулдан тандалтын нэгжийн тархвар судлагч эсхүл дүн бүртгэгч нь ТТӨ, АЗЦХХ-ын мэдээг нэгтгэн, удирдах албан тушаалтнаар хянуулсны дараа мэдээлнэ (хүснэгт 1).

Хүснэгт 1. ТТӨ, АЗЦХХ-ын мэдээ өгөх хүснэгт

№	Мэдээний төрөл	Мягтын дугаар	Харуулдан тандалтын нэгж			Хэрхэн мэдээлэх
			Өрх, сумын ЭМТ	БООТ, НЭ	Аймгийн ЭМГ, дүүргийн ЭМТ	
1	Амбулаторид суурилсан тандалтын мэдээ	№1	Өдөр бүрийн 12 цагаас өмнө	Өдөр бүр, 12 цагаас өмнө	Мягмар гараг бүр, 12 цагаас өмнө	ИСТМС (http://is.flu.mn)
2	Эмнэлэгт суурилсан тандалтын мэдээ	№2	-	Мягмар гараг бүр, 12 цагаас өмнө	-	ИСТМС (http://is.flu.mn)
3	ТТӨ-ий тархалтын үе шатаас хамаарч	№3		Мягмар гараг бүр, 12 цагаас өмнө		ИСТМС (http://flu.mn/metadata)
	Алаг цроог дэгдэлт ийн үед					
	мэдээлэл цуглуулах мэдээ			Өдөр бүр, 12 цагаас өмнө		ИСТМС (http://flu.mn/metadata)
4	ТТӨ-ий "Тажалт тархалт"-ын үед цуглуулах мэдээ	№4		Өдөр бүр, 12 цагаас өмнө		ИСТМС (http://flu.mn/metadata)
5	АЗЦХХ-ын шалтгаант нас баралтын мэдээ	№5	-	48 цагийн дотор	-	nicmongolia@ncsd.gov.mn
6	Бүсийн болон салбар лабораторийн шинжилгээ хийсэн сорьцын мэдээлэл	№6		Даваа гараг бүр, 12 цагаас өмнө		virologylabmng@ncsd.gov.mn

ЗОРИЛГО 1

Хэзээ, хаана томуугийн идэвхжил нэмэгдэж байгаа болон хэн илүү өртсөн болохыг тодорхойлох:

- ❖ Эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн ажилтнуудад анхааруулга, сануулга өгөх – эргэн мэдээлэл бэлтгэх
- ❖ Тархалтыг хяналтанд авахын тулд томуугийн эсрэг вакцинаар хэнийг, хэзээ дархлаажуулах – эрсдэлт бүлгийн хүн ам, хугацааг тогтоох
- ❖ Эмийн болон эмийн бус урьдчилан сэргийлэлт, эмчилгээний талаар баримтлах бодлого, зөвлөмжийн талаар мэдээлэх – ямар үйл ажиллагаа илүү үр дүнтэй болохыг тодорхойлох.

ЗОРИЛГО 2

Томуу, томуу төст вирусийн антигений болон генетикийн өөрчлөлт, вирусийн эсрэг эм бэлдмэлд мэдрэг байдлыг илрүүлэх:

- ❖ Эмч нарт вирусийн эсрэг ямар эм, эмийн бэлдмэл хэрэглэхийг зөвлөх, мэдээлэх
- ❖ Тухайн томуугийн улиралд хэрэглэгдэх томуугийн эсрэг вакцины омгийн сонголтонд хувь нэмэр оруулах

ЗОРИЛГО 3

Томуугийн улмаас хүндэрч болзошгүй эрсдэлт бүлгийн хүн амыг тодорхойлж, хяналтанд авах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, нөөцийг зөв зохистой хуваарилах. Өвчлөлийн эмнэлзүйн явцыг тодорхойлох:

- ❖ Эрсдэлтэй бүлгийн өвчтөнд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээ, урьдчилан сэргийлэлтийг сайжруулах, нэмэгдүүлэх
- ❖ Томуугийн эсрэг дархлаажуулалт, эмчилгээнд хамгийн эхэнд хамрагдах эрсдэлт бүлгийн хүмүүсийг тодорхойлж, үндэсний хэмжээнд бодлогын шийдвэр гаргахад оролцох

ЗОРИЛГО 4

Жил бүрийн томуу, томуу төст өвчний дэгдэлт болон томуугийн шинэ вирусээр үүсгэгдсэн цартахлын явц, цар хүрээг үнэлэх, хяналт тавих:

- ❖ Хүн амыг өвчлөл, үгдрэл, хүндрэлээс сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд бодлого хэрэгжүүлэгчтэй хамтран ажиллах
- ❖ Хүн амын дунд авч хэрэгжүүлэх арга хэмжээний үр дүнг тооцох, хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх, ямар арга хэмжээ илүү үр дүнтэй байгааг мэдээлэх

ЗОРИЛГО 5

Томуугийн шалтгаант өвчлөлийн дарамтыг тооцох:

- ❖ Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хязгаарлагдмал нөөцийг эхний ээлжинд эрсдэлт бүлгийн хүн амд хуваарилах, зөв зүйтэй шийдвэр гаргахад туслах
- ❖ Тухайн томуугийн улирал, тухайн газар нутагт явагдсан томуугийн дэгдэлтийг харьцуулан судлах, нөлөөлж буй хүчин зүйлийг судлах үндэслэл гаргах
- ❖ Томуугийн дарамтын талаархи дэлхий дахины ойлголтыг нэмэгдүүлэхэд нэмэр хандив болох

ЗОРИЛГО 6


Өвөрмөц, ер бусын үйл явдлыг эрт илрүүлэх:

- ❖ Олон улсын анхааралд орохуйц улс орнуудын Олон Улсын Эрүүл Мэндийн Дүрмийн Зохицуулагчид мэдээлэхүйц нийгмийн эрүүл мэндэд эрсдэл учруулах үйл явдлыг эрт илрүүлэх

ЗОРИЛГО 7

Өвчлөлийн цаашдын хандлага, хэтийн төлөв, дэгдэлтийн үе шатыг тодорхойлох:

- ❖ Өвчлөлийн цаашдын хандлага
- ❖ Улирлын томуу, томуугийн цартахлын хүндрэлийн үнэлгээг хийх



Өнэхүү тандалтын мэдээг зөвхөн байгууллагын дотоод харагцаанд зориулж гаргав

ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧНИЙ МЭДЭЭ

39 дүгээр долоо хоног (2022 оны 9 дүгээр сарын 28-наас 10 дугаар сарын 2-ныг дуустал)

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

- Улсын хэмжээнд амбулаториор 232,816 хүн үйлчлүүлсний 17,277 (7.4%) нь ТТӨ-тэй, эмнэлэгт хэвтэн эмлүүлж буй 7,489 хэвтэгсдийн 795 (10.6%) нь АЗЦОХ-ын шалтвантай байна.
- Улсын хэмжээнд томуу, томуу төст өвчний тархалтын түвшин “Улирлын томуу, томуугийн цартахлын хүндрэлийн үнэлгээ (УТТЦХУ)”-гаар **ИДЭВХЖЛИЙН ТҮВШИНД** байна.
- УТТЦХУ-гаар **улирал хоорондын түвшинд 5** (өмнөх долоо хоногт-9), **идэвхжлийн түвшинд 15** (өмнөх долоо хоногт-11) аймаг байна. Өмнөх долоо хоногтой харьцуулахад Булган, Сэлэнгэ, Увс аймгууд улирал хоорондын түвшнээс идэвхжлийн түвшинд шилжсэн байна. Хэнтэй аймаг мэдээ ирүүлээгүй байна.
- Нийт эмнэлэгт хэвтэгсдийн дотор АЗЦОХ 10.6% (Улаанбаатар 14.1%, аймаг 8.2%)-ийг эзэлж, өмнөх долоо хоногтой харьцуулахад 1.5%-иар нэмэгдэж, өнгөрсөн оны мөн үеэс 19.8%-иар бага байна.
- 2022 оны 10-р сарын 03-ны өдрийн байдлаар аймаг, дүүргийн хэмжээнд хүрхдийн тэсвэгт хэвтэн эмлүүлж буй хүрхдийн 52.7% (орон нутаг 37.1%, нийслэл 70.5%) АЗЦОХ-тай ба өмнөх 7 хоногтой харьцуулахад 2.4%-иар нэмэгдсэн байна.
- ТТӨ-ий шалтвантай түргэн тусламжийн дуудлага улсын хэмжээнд нийт дуудлагын 9.4% (Улаанбаатар 12.8%, аймаг 14.0%)-ийг эзэлж, өмнөх долоо хоногтой харьцуулахад 2.3%-иар бага байна.
- АЗЦОХ-ын шалтвантай нас баралт Хан-Уул дүүрэгт-1, Дархан-Уул аймагт-1, нийт 2 тохиолдол бүртгэгдсэн байна.
- ХБСҮТ-ийн Вирус судлалын лабораторид томуугийн харуулдан тандалтын эмнэлгээс ирсэн 79 сорьцонд илрүүлэх шажмалсаа хийхэд 17 (21.5%), сорьцонд риновирус, 2 (2.5%), сорьцонд бокавирус, 1 (1.3%) сорьцонд амьсгалын замны-синцитиал вирус тус тус илэрсэн байна. **Салбар болон бусийн лабораториос мэдээ ирүүлээгүй байна**

ӨВЧЛӨЛИЙН БАЙДАЛ:

Түүхэлтэй	Байршил	Тайлбар: Гейн 7 хоногт	Өмнөх 7 хоногт		Өмнөх оны мөн үе		Сүүлийн 7 хоногийн өөрчлөлт	
			Түвшин	Харьцах дараа	Түвшин	Харьцах дараа	Түвшин	Харьцах дараа

1. Өвчлөлийн нөхцөл байдлын танилцуулга
2. Нотолгоонд суурилсан шийдвэр гаргах
3. Халдварын хяналт, хариу арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх
4. Тандалтын тоон мэдээний чанарын хяналтыг хийх

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА